



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/75

Мандагнов

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн  
үйл ажиллагаа зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ын 3.1 дэх хэсэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Хүүхдийн эрхийг хамгаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай" 02 дугаар албан даалгавар, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, эсэн мэнд амьдрах нөхцөл боломжоор ханган хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор "Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги"-ийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-30-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. "Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги"-ийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 835,500 (Найман зуун гучин таван мянга таван зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг), гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

431190-01